



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 дугаар сарын 4-ний өдөр      Дугаар А/282      Улаанбаатар хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, 268<sup>1</sup> дугаар зүйлийн 268<sup>1</sup>.1.1 дэх заалт, 269<sup>1</sup> дүгээр зүйлийн 269<sup>1</sup>.1.1 дэх заалт, 270<sup>1</sup> дугаар зүйлийн 270<sup>1</sup>.1.4 дэх заалт, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.1, 271<sup>1</sup>.1.2 дахь заалт, Мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэ журмыг гаалийн харилцаанд оролцогчдод сурталчлан таниулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн хэлтэс /С.Оюунцэцэг/, Гаалийн хяналт, шалгалтын газар /П.Баттөр/-т үүрэг болгосугай.
- 3.Шинэчлэн батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг CAIS системийн ангилалтын санд оруулахыг Мэдээллийн технологийн төв /Б.Ганзориг/-д даалгасугай.
- 4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/43 дугаар тушаал, Гаалийн ерөнхий газрын даргын 2018 оны А/110 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА      Б.АСРАЛТ